

“ЭРДЭНЭС СОЛЮШИНС” ХК

2022 оны 09 дүгээр сарын 12-ний өдөр

№ ХТ 03/2022

Улаанбаатар хот

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал 2022 оны 09 дүгээр сарын 12-ний өдрийн 12.00 цагаас 12.50 цагын хооронд Google Meet joining info Video call link: <https://meet.google.com/pmd-rsqc-pye> програмыг ашиглан хуралдав.

Хурал зохион байгуулах комисс болон Тооллогын комиссоос хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд оролцохоор ирсэн хувьцаа эзэмшигчдийн ирцийг бүртгэж, ирц 122,274,657 ширхэг буюу 69.64% - ийн саналын эрхтэй хувьцааг эзэмшигчид оролцож байгаа талаар танилцуулж, хурлын ирц компанийн дүрэм болон хуулийн дагуу бүрдсэн тул хурал хүчин төгөлдөрт болсон тухай Тооллогын комиссын шийдвэрийг танилцуулав. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд Субашид тек ХХК-ийг төлөөлж Гүйцэтгэх захирал Т. Золбоо, хувьцаа эзэмшигч Г. Дулмааг төлөөлж иргэн Б.Батхүү нар итгэмжлэлээр хуралд оролцов. Компанийн зүгээс цахим хурлыг бичлэг хийж хадгалав.

Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах шийдвэрийн 2 дугаар хавсралтад заасан “Хурлын хөтөлбөр, дэг”-ийн дагуу хэлэлцэх асуудлыг хурлын эхэнд хурлын дарга хувьцаа эзэмшигчдэд танилцуулж хурлыг нээв.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар дараах асуудлуудыг хэлэлцэв. Үүнд:

1. Монголын хөрөнгийн биржээр нийтэд санал болгон эргэлтэд нэмж гаргасан 17,706,154 (арван долоон сая долоон зуун зургаан мянга нэг зуун таван дөрөв) ширхэг энгийн хувьцааг бүртгэх тухай;
2. Компанийн дүрмийн шинэчилсэн төсөл;
3. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд сонгох.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Т.Золбоо: Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын хөтөлбөрийн дагуу хурлыг нээж хурлаар хэлэлцэх дээр асуудлуудын талаар танилцуулав.

1-р хэлэлцэх асуудлаар:

Т.Золбоо: Компанийн энэ 7-рсард нэмж энгийн хувьцаа гаргаж 17,706,154 ширхэг энгийн гаргаж, 1.9 тэрбум төгрөг татан төвлөрүүлсэн энэ хувьцааг бүртгэж, дүрмэндээ тусган батлах шаардлагатай байна. Энэ талаар санал хураалт явуулья.

Тооллогын комис хэлэцэж буй асуудал тус бүрээр санал хураалт явуулж, Санл хураалтын үр дүнг хувьцаа эзэмшигчдийн хуралд мэдээлэв.

Хувьцаа эзэмшигчидээс ямар нэгэн санал, асуулга явагдсангүй тул санал хэлэлцэж байгаа асуудлаар санал хураалт явуулья. Хэлэлцэх асуудал тус бүрийг цахимаар гар өргөж санал аа өгнө үү. Тооллогын комисс үүнийг бүртгэж авна уу.

Тооллогын комиссын дарга Г. Төгөлдөр: Тооллогын комиссын тогтоолыг танилцуулав. Үүнд хэлэлцэж буй 3 асуудлаар хувьцаа эзэмшигчид санал ирүүлээ. Өөр брокерийн компаниар дамжуулан ямар нэгэн саналын хуудас ирсэнгүй болно. Хуралд оролцож буй санал өгсөн саналын хуудсыг тоолоход хүчингүй болсон, түдгэлзсэн, эсрэг саналтай саналын хуудас гарсангүй. Саналын хуудас дараах байдалтай байна. Үүнд:

№	Хэлэлцсэн асуудлууд	Ээлжит хуралд оролцож буй санал өгөх эрхтэй хувьцаа эзэмшигчдийн				Нийт
		Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн	Хүчингүй болсон	

2022 ОНЫ 09-Р САРЫН 12-НИЙ ӨДРИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН
ДАРГА / Т. ЗОЛБОО/



		ширхэг	хувь	ширхэг	хувь	ширхэг	хувь	ширхэг	хувь	ширхэг	хувь
1	Монголын хөрөнгийн биржээр нийтэд санал болгон эргэлтэд нэмж гаргасан 17,706,154 (арван долоон сая долоон зуун зургаан мянга нэг зуун таван дөрөв) ширхэг энгийн хувьцааг бүртгэх тухай	122,274,657	100%							122,274,657	100%
2	Компанийн дүрмийн шинэчилсэн төсөл батлах тухай	122,274,657	100%							122,274,657	100%

Хурлын дарга Т.Золбоо: Хуралд оролцож буй хувьцаа эзэмшигчид 100% санал нэгтгэйгээр хэлэцэж буй

3-р хэлэлцэх асуудлаар:

Т.Золбоо: Компанийн ТУЗ-д Ердийн гишүүнээр Ц.Хүдэрмөнх, Т.Золбоо, Ц.Хуяг, Ц.Хишигбаатар, Б.Батхүү, Г.Аззаяа нарыг, Хараат бус гишүүнээр Б.Долгорсүрэн, С.Энхжаргал, Б.Ган-Од нар нэр дэвшүүлсэн байна. Үүнийг дүрмэнд тусгасаны дагуу кумулятив аргаар хүн тус бүрээр санал хураана. ТУЗ-ын нэр дэвшигчдийн анкеттай та бүхэн урьдчилан танилцсан байх асуух асуулт байна уу.

Асуулт байхгүй бол хувьцаа эзэмшигч тус бүрээр санал асуулт дэмжсэн татгалзсан түдгэлзсэн талаар санал хураалт явуулав. Хөтөлбөрийн дагуу хэлэлцэж буй асуудлуудтай холбоотой санал, асуулга явуулья. Хувьцаа эзэмшигчидээс ямар нэгэн санал, асуулга явагдсангүй тул санал хэлэлцэж байгаа асуудлаар санал хураалт явуулья. Хэлэлцэх асуудал тус бүрийг цахимаар гар өргөж санал аа өгнө үү. Тооллогын комисс үүнийг бүртгэж авна уу. Хэлэлцэж буй асуудлуудыг дэмжсэн байна. Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийн төсөлд ямар нэгэн санал байна уу.

Хувьцаа эзэмшигчид 100% санал нэгтгэйгээр саналгүй тул Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарч буй шийдвэрийг уншиж танилцуулав.

“ЭРДЭНЭС СОЛЮШИНС” ХК-НЫ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИДИЙН 2022 ОНЫ 09-Р САРЫН 12-НИЙ ӨДРИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛААС ДАРААХ АСУУДЛУУДЫГ ШИЙДВЭРЛЭВ. ҮҮНД:

1. Монголын хөрөнгийн биржээр нийтэд санал болгон эргэлтэд нэмж гаргасан 17,706,154 ширхэг энгийн хувьцааг бүртгэв.
2. Компани нэмж энгийн хувьцаа нийтэд гаргаж, бүртгэсэнтэй холбоотойгоор Компанийн дүрмийн шинэчилсэн төсөлийг батлав.
3. Компанийн 2022 оны 09 дүгээр сарын 12-ний өдрийн ээлжит бус хурлын 12.00 цагт Google Meet joining info Video call link: Google Meet joining info Video call link: <https://meet.google.com/pmd-rsqc-pye> байхаар зарлан хуралдуулсан видео бичлэгийг хадгалахаар шийдвэрлэв.
4. Компанийн ТУЗ-ын Ердийн гишүүнээр Ц.Хүдэрмөнх, Т.Золбоо, Ц.Хуяг, Ц.Хишигбаатар, Б.Батхүү, Г.Аззаяа нарыг, Хараат бус гишүүнээр Б.Долгорсүрэн, С.Энхжаргал, Б.Ган-Од нарыг 3-н жилийн хугацаатайгаар шинээр томилов.

ХУРЛЫН ДАРГА

/Т.ЗОЛБОО/

2022 ОНЫ 09-Р САРЫН 12-НИЙ ӨДРИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ДАРГА

/Т.ЗОЛБОО/